



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 25 өдөр

Дугаар A/491

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Барилгын тухай 35 дугаар зүйлийн 35.1.1, 35.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөвсгөл аймаг дахь Политехник коллежийн дотуур байр болон хичээлийн байрууд нь ашиглалтын шаардлага хангахгүй болсны улмаас цаашид сургалтын үйл ажиллагаа явуулахад хүндрэл бэрхшээлтэй болсон бөгөөд уг барилга байгууламжуудад үзлэг, шинжилгээ хийж холбогдох дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Оюунтуяа (Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)

Гишүүд:

П.Галсандорж (Нийгмийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Х.Даваасүрэн (Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

Н.Шинэбаяр (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга хот байгуулалтын хэлтсийн мэргэжилтэн)

Д.Мягмарсүрэн (Барилгын техникийн хяналтын улсын байцаагч)

Н.Баатар-Очир (Хөвсгөл аймаг дахь политехник коллежийн захирал)

Нарийн бичгийн дарга: Б.Энхжаргал (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга хот байгуулалтын хэлтсийн дарга)

2. Дээрх үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомж, журамд нийцүүлэн шуурхай зохион байгуулж, явцыг тухай бүр танилцуулан ажиллахыг Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга (Б.Оюунтуяа)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-т даалгасугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ

Захирамж-2023

6710011058